



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 306

Улаанбаатар хот

**Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэс Монгол" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 210,700,000.00 (хоёр зуун арван сая долоон зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 119,396,666.49 (нэг зуун арван есөн сая гурван зуун ерэн зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 93-92 УБЗ улсын дугаартай, Ланд круйзер-200 маркийн автомашиныг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадагва, "Эрдэнэс Монгол" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэх, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

137005005
15-r_huraldaan.docx